НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ХҮН АМ

2018

Улаанбаатар хот

2019 он

НИЙСЛЭЛИЙН ӨРХ, ХҮН АМ
2018 он



Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 45.3 хувь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод оршин сууж байна. 2005 онд нийслэлийн хэмжээнд нэг км² нутаг дэвсгэрт 202 хүн оршин сууж байсан бол 2018 онд 305 хүн болж нэмэгдсэн. Нийслэлийн хэмжээнд хүн амын нягтрал 2005-2018 оны хооронд 51.0 хувиар өссөн байна.

Байшин хороололд амьдардаг өрх

175 445

Гэр хороололд амьдардаг өрх

212 008

Нийт 387 453 өрхийн 54.7% нь байшин хороололд, 45.3% нь гэр хороололд амьдарч байна.

Нийтийн орон сууцанд

173 526 (44.8%)

Бие даасан тохилог сууцанд

3 898 (1.0%)

Сууцны тусдаа байшинд

109 570 (28.3%)

Монгол гэрт

100 312 (25.9%)

Орон гэргүй өрх, хүний тоо

147 өрхийн 303 хүн

НИЙСЛЭЛИЙН ХҮН АМ

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 45.3 хувь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод оршин сууж байна. Нийслэлийн хүн амын 95.0 хувь нь төвийн 6 дүүрэгт тодруулбал, Баянзүрх дүүрэгт 23.8 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 22.2 хувь, Баянгол дүүрэгт 15.7 хувь, Хан-Уул дүүрэгт 12.4 хувь, Чингэлтэй дүүрэгт 10.9 хувь, Сүхбаатар дүүрэгт 10.1 хувь, үлдсэн 4.9 хувь нь Налайх, Багануур, Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

Зураг 1. Монгол Улсын хүн ам, бүсээр



Зураг 2. Хүн амын тархалт, дүүргээр



2000 онд нийслэлийн хэмжээнд нэг км^2 нутаг дэвсгэрт 163 хүн оршин сууж байсан бол 2018 онд 305 хүн оршин суух болжээ. Нийслэлийн хэмжээнд хүн амын нягтрал 2000-2018 оны хооронд 87.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Суурин хүн амын тоо, хүн амын нягтрал, дүүргээр

Дүүрэг	Нутаг дэвсгэр[1] (км^2)	Хүн амын тоо (мянган хүн)					Хүн амын нягтрал, нэг км^2-д[2]				
		2000	2006	2016	2017	2018	2000	2006	2016	2017	2018
Нийслэлийн дүн	4 735.1	773.6	1 067.5	1 380.8	1 417.4	1 444.7	163	225	292	299	305
Баянзүрх	1 236.1	149.6	235.2	327.1	336.9	343.6	121	190	265	273	278
Сонгинохайрхан	1 200.1	158.6	232.3	315.8	322.5	321.2	132	194	263	269	267
Баянгол	24.4	141.0	169.3	214.3	221.4	226.9	5 779	6 938	8 784	9 074	9 299
Хан-Уул	501.9	72.6	98.8	159.5	169.7	178.9	145	197	318	338	356
Чингэлтэй	91.7	108.7	140.0	158.0	159.1	157.3	1 185	1 185	1 723	1 735	1 715
Сүхбаатар	210.8	95.5	133.1	136.6	138.0	145.3	453	453	648	655	689
Налайх	689.0	23.4	29.1	36.4	36.9	37.6	34	42	53	54	55
Багануур	625.0	20.7	25.9	29.0	28.8	29.5	33	41	46	46	46
Багахангай	156.1	3.5	3.7	4.1	4.1	4.4	22	23	26	26	28

Нийслэлийн Баянгол (9299), Чингэлтэй (1715), Сүхбаатар (689) дүүрэгт хүн амын нягтрал хамгийн их байгаа нь нийслэлийн дунджаас 2.2-30.5 дахин их байна. Харин Налайх дүүрэгт 55, Багануур дүүрэгт 46, Багахангай дүүрэгт 28 байгаа нь хүн амын нягтрал хамгийн бага болохыг харуулж буй үзүүлэлт юм.

[1] Хот байгуулалтын мэдээллийн сангийн UTM координатын системд бүртгэгдсэн мэдээлэл.

[2] Тухайн оны суурин хүн амын тоонд үндэслэн тооцов.

Зураг 3. Хотуудын хүн амын эзлэх хувь



Нийслэл нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлж, хүн амын нягтралаар хамгийн өндөр хот хэвээр байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын 2147.4 мянга (67.4%) нь хотын хүн ам буюу аймгийн төв, нийслэл, тосгоны хүн ам юм. Хотуудын хүн амын 67.3 хувь нь нийслэл хотод оршин сууж байна.

Нэг км^2 газарт ногдох хүний тоо буюу хүн амын нягтрал нийслэл хотод 305 хүн байгаа нь Монгол Улсын томоохон суурин газрууд болох Орхон (133), Дархан-Уул (32) аймгуудаас даруй 2.3 - 9.5 дахин их нягтралтай байна.

Хүснэгт 2. Нийслэлийн хүн ам, хороодын бүлгээр, 2018 он

Бүлгийн интервал (хүн амаар)	Бүлэгт хамаарах хорооны тоо	Бүлгийн хүн амын тоо	Дүнд эзлэх хувь
600-5000	20	71 088	4.9
5001-6500	21	119 905	8.3
6501-8000	28	201 959	14.0
8001-10000	24	212 102	14.7
10001-12000	18	197 948	13.7
12001-15000	24	318 553	22.0
15001+	17	323 114	22.4

Нийслэл хот 2011 оноос эхлэн засаг захиргааны анхан шатны 152 нэгжтэй болсон. 2018 онд нэг хороонд дунджаар 9504 хүн оршин суух болж өмнөх оноос 180 хүнээр нэмэгдсэн байна. Энэ нь аймгуудын нэг сумын дундаж хүн амын тооноос даруй 1.8 дахин илүү байгаа юм.

Нэг хороонд ногдох хүн амын тоогоор Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүрэг тэргүүлж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15-р хороонд хамгийн их буюу 25406 хүн оршин сууж байхад Багануур дүүргийн 2-р хороонд хамгийн бага буюу 695 хүн оршин сууж байна.

2018 онд нийслэлийн суурин хүн амын тоо 1444669 (698643 эрэгтэй, 746026 эмэгтэй) болж өмнөх оноос 27.3 мянган хүнээр (1.9%) өссөн байна. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурдыг тооллого явагдсан онуудаар авч үзвэл 1956-1963 онд хамгийн өндөр буюу 9.5 хувиар өссөн байна. Энэ нь тухайн үед хүн амаа өсгөх, төрөлтийг нэмэгдүүлэх талаар төрөөс томоохон бодлогуудыг баримталж байсантай холбоотой юм. Тухайлбал, олон хүүхэд төрүүлсэн эхийг алдарт эхийн одонгоор шагнах, хүүхдийн мөнгө олгох, ихэр хүүхдийг улсаас халамжлах гэх мэт бодлогуудыг хэрэгжүүлсэн байна. Дээрх огцом өсөлтийн дараах жилүүдэд хүн амын өсөлт харьцангуй буурч эхэлсэн бөгөөд 1963-1969 онуудад 3.0 хувь хүртэл буурсан байдаг.

Зураг 4. Нийслэлийн хүн амын өсөлт



Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдэж, мөн хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирэгсдийн тоог хязгаарлах болсноор нийслэлийн хүн амын өсөлтөд ердийн өсөлтийн эзлэх хувийн жин нэмэгдсэн. Тухайлбал, 2000 онд шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент буюу 1000 хүн ам тутамд ногдох механик өсөлт 25 байсан нь ердийн хөдөлгөөний цэвэр коэффициент буюу 1000 хүн ам тутамд ногдох ердийн цэвэр өсөлтөөс 3 дахин их байсан бол 2018 онд 1000 хүн ам тутамд ногдох цэвэр өсөлтийн түвшин механик өсөлтийн түвшнээс 97 дахин илүү болсон байна.

Хүснэгт 3. Хүн амын цэвэр өсөлт

Үзүүлэлт		2000	2008	2016	2017	2018
Нийслэл	Төрсөн хүүхдийн тоо	11 771	25 426	39 074	35 862	35 300
	Нас барсан хүний тоо	5 037	6 336	7 275	7 605	7 561
	Хүн амын цэвэр өсөлт	6 734	19 090	31 799	28 257	27 739
Улсын дүн	Төрсөн хүүхдийн тоо	48 721	63768	79 920	75 321	78 444
	Нас барсан хүний тоо	15 472	15 413	17 763	17 357	17 864
	Хүн амын цэвэр өсөлт	33 249	48 355	62 157	57 964	60 580
Цэвэр өсөлтөд нийслэлийн эзлэх хувийн жин		20.3	39.5	51.2	48.7	45.8

2018 онд нийслэлийн хэмжээнд нийт 35282 эхээс 35300 хүүхэд мэндэлж, 7561 хүн нас барж, ердийн цэвэр өсөлт 27739 хүнээр нэмэгдсэн байна. Монгол Улсын хүн амын цэвэр өсөлтөд нийслэлийн эзлэх хувийн жин 2000 онд 20.3 байсан бол жил ирэх тутамд өсөн нэмэгдсээр 2018 онд 45.8 хувьд хүрэв.

Хүснэгт 4. Жилийн эцсийн суурин хүн амын тооцоо

Үзүүлэлт	2000	2008	2016	2017	2018
Жилийн эхний хүн ам	760 077	1 025 174	1 345 500	1 380 792	1 417 496
Төрсөн хүүхэд	11 771	25 426	39 074	35 862	35 300
Нас барсан хүн	5 037	6 336	7 275	7 605	7 561
Шилжин ирсэн хүн	19 918	33 407	25 196	10 335	6 568
Шилжин явсан хүн	592	10 199	14 342	11 431	6 328

1990 оноос хойш нийслэлд хөдөө, орон нутгаас 640 мянган хүн шилжин ирж, 191 мянган хүн хөдөө орон нутаг руу шилжиж явсан байна. Монгол Улсын Дээд Шүүхийн шийдвэрээр нийслэлд шилжин суурьших иргэдээс авч байсан “төлбөр”цуцлагдсаны улмаас 2004 онд хамгийн олон буюу 68.8 мянган хүн нийслэлд албан ёсоор шилжин ирж байв. Гэхдээ эдгээр хүмүүсийн 27.2 мянга нь нийслэлд олон жилийн өмнөөс суурьшиж, суурин хүн амын тоонд бүртгэгдэж ирсэн байдаг.

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/17 “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамжийн 1 дүгээр зүйлд “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай болон Улаанбаатар хотод орон сууц худалдан авснаас бусад хөдөө, орон нутгаас нийслэлд байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөн”-ийг түр зогсоосонтой холбоотойгоор шилжин ирэгсдийн тоо 6568 болж сүүлийн 20 жилд тохиолдоогүй бууралт гарсан.

Нийслэлийн хэмжээнд 2018 онд 6568 хүн албан ёсоор шилжин ирснээс 2219 (33.8%) нь Баянзүрх, 1070 (16.3%) нь Сонгинохайрхан, 1253 (19.1%) нь Баянгол, 946 (14.4%) нь Хан-Уул, 474 (7.2%) нь Сүхбаатар, 298 (4.5%) нь Чингэлтэй, 308 (4.7%) нь Багануур, Багахангай, Налайх дүүрэгт тус тус суурьшсан байна.

Хүснэгт 5. Нийслэлийн хүн амын шилжих хөдөлгөөн

Үзүүлэлт	2000	2008	2016	2017	2018
Шилжин ирсэн	19 918	33 407	25 196	10 335	6 568
Шилжин явсан	592	10 199	14 342	11 431	6 328
Механик өсөлт	19 326	23 208	10 854	-1 096	240
Шилжин ирэлтийн коэффициент	26.0	31.9	18.5	7.4	4.6
Шилжин явалтын коэффициент	0.8	9.7	10.5	8.2	4.4

2018 онд нийслэлээс 6328 хүн бусад аймаг, орон нутаг руу албан ёсоор шилжин явжээ. Нийслэлийн хэмжээнд 2018 онд 1000 хүн ам тутамд ногдох шилжин ирсэн хүний тоо 5 болж 2000 оноос 21 хүнээр буурч, шилжин явсан хүний тоо 4 болж 2000 оноос 3 хүнээр өссөн байна.

Нийслэлийн нийт хүн амын 63.3 хувь нь 35 хүртэл насны залуучууд байна. Тодруулбал, нийт хүн амын 470016 (32.5%) нь 0-15 насны хүүхэд, 876055 (60.6%) нь 16-59 насны хүмүүс, 98598 (6.8%) нь 60 ба түүнээс дээш насны өндөр настнууд байна.

Зураг 5. Хүн амын нас, хүйсийн суварга, 2000, 2018 оны жилийн эцэс



Хүснэгт 6. Нийслэлийн суурин хүн амын тоо, нас, хүйсийн бүтцээр

Насны бүлэг	2000		2008		2016		2017		2018	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Бүгд	760 077	390 931	1 067 472	553 403	1 380 792	718 892	1 417 396	737 838	1 444 669	746 026
0-4	60 965	30 264	99 264	48 914	179 506	87 778	178 319	87 267	182 016	88 599
5-9	75 892	37 912	87 598	43 558	140 362	68 925	151 223	74 702	165 776	81 143
10-14	91 975	45 977	93 107	46 487	86 704	42 338	94 716	46 551	105 373	51 566
15-19	91 152	47 243	109 781	55 434	88 152	44 414	88 112	44 179	86 008	42 307
20-24	86 928	45 926	113 933	59 562	104 399	54 508	97 614	50 809	93 243	48 038
25-29	76 592	39 269	100 035	53 040	152 785	79 878	148 878	78 328	134 903	70 364
30-34	64 512	33 362	91 811	48 176	135 422	70 657	142 645	74 133	147 527	76 062
35-39	60 734	31 393	81 201	42 537	110 161	57 672	114 660	59 932	115 130	59 268
40-44	44 973	23 257	73 465	38 693	97 122	51 532	100 308	53 019	100 702	52 751
45-49	29 126	15 005	65 116	34 822	78 726	42 425	82 850	44 140	84 110	44 310
50-54	20 963	10 820	48 535	25 853	69 134	38 046	70 028	38 507	71 158	38 849
55-59	17 992	9 230	33 421	17 685	52 569	29 734	56 027	31 758	60 125	33 757
60-64	12 939	6 658	24 369	13 142	32 847	18 996	35 650	20 673	39 717	23 133
65-69	10 783	5 960	18 976	10 115	20 493	12 272	22 594	13 310	23 486	14 110
70+	14 551	8 655	26 860	15 385	32 410	19 717	33 772	20 530	35 395	21 769

Нийслэлийн хүн амын хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 93.6 болж 2000 оноос 1 хүнээр буурсан байна. Энэ нь хүн амын нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр байгаа мөн хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийн дунд эмэгтэйчүүд илүү байгаатай холбоотой.

Хүснэгт 7. Нийслэлийн хүн амын хүйсийн харьцаа, насны бүлгээр

Насны бүлэг	2000	2008	2016	2017	2018
Бүгд	94.4	92.9	92.1	92.1	93.6
0-4	101.4	102.9	104.5	104.3	105.4
5-9	100.2	101.1	103.6	102.4	104.3
10-14	100.0	100.3	104.8	103.5	104.3
15-19	92.9	98.0	98.5	99.4	103.3
20-24	89.3	91.3	91.5	92.1	94.1
25-29	95.0	88.6	91.3	90.1	91.7
30-34	93.4	90.6	91.7	92.4	94.0
35-39	93.5	90.9	91.0	91.3	94.3
40-44	93.4	89.9	88.5	89.2	90.9
45-49	94.1	87.0	85.6	87.7	89.8
50-54	93.7	87.7	81.7	81.9	83.2
55-59	94.9	89.0	76.8	76.4	78.1
60-64	94.3	85.4	72.9	72.4	71.7
65-69	80.9	87.6	67.0	69.8	66.4
70+	68.1	74.6	64.4	64.5	62.6

Төрөх үеийн хүйсийн харьцаагаар 100 эмэгтэй хүүхдэд ногдох эрэгтэй хүүхдийн тоо байнга давамгайлж байгаа боловч насны түвшин нэмэгдэх тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч байна.

Хүснэгт 8. Төрөх үеийн хүйсийн харьцаа болон хүн ам зүйн ачаалал, дүүргээр

Дүүрэг	Төрөх үеийн хүйсийн харьцаа					Хүн ам зүйн ачаалал				
	2001	2008	2016	2017	2018	2001	2008	2016	2017	2018
Нийслэлийн дундаж	104	104	106	108	105	59.0	53.0	58.4	60.2	64.9
Багануур	107	96	109	105	109	86	55.8	58.9	58.6	68.9
Багахангай	94	131	88	111	88	85	61.4	60.7	63.4	66.1
Баянгол	93	105	105	111	110	54	49.0	57.6	61.6	62.8
Баянзүрх	110	106	106	108	103	58	51.8	55.8	57.9	68.7
Налайх	107	101	102	115	102	72	56.1	63.0	64.3	64.5
Сонгинохайрхан	102	101	105	107	105	62	53.6	58.6	58.6	65.4
Сүхбаатар	104	107	104	105	106	57	55.4	60.5	62.3	69.1
Хан-Уул	101	98	110	104	103	61	49.5	62.4	65.3	63.0
Чингэлтэй	113	113	105	109	105	58	55.6	57.5	59.1	64.9

2018 оны жилийн эцэст нийслэлд 60-аас дээш насны 98598 өндөр настан оршин сууж байсны 39586 (40.1%) нь эрэгтэй, 59012 (59.9%) нь эмэгтэйчүүд байв.

Зураг 6. 60 ба түүнээс дээш насны өндөр настан, хүйсээр, 2018 он



16 хүртэлх насны хүүхэд болон 60 ба түүнээс дээш насны өндөр настай хүн амын нийлбэрийг 16-59 насны хүн амд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг хүн ам зүйн ачаалал 2018 онд 64.9 хувь болж өмнөх оноос 4.7 пунктээр өссөн.

Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн насны 100 хүн бүр 65 хүнийг тэжээж байгаагийн 54 нь хүүхэд, 11 нь өндөр настнууд байна.

Төрөлтийн ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох төрөлт 2018 онд 24.7 болж 2010 оноос 2.7 промилээр өссөн бол нас баралтын ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох нас баралт 5.3 болж 2010 оноос 0.5 промилээр буурсан байна.

Нийслэлийн хэмжээнд 2018 онд нийтдээ 35300 хүүхэд мэндэлсэн нь 2000 оноос 23529 хүүхдээр буюу 3.0 дахин өсөв. 2018 онд мэндэлсэн нийт хүүхдийн 3.5% нь 19 хүртэлх насны эхээс, 17.2% нь 20-24 насны эхээс, 32.6% нь 25-29 насны эхээс, 27.3% нь 30-34 насны эхээс, 15.1% нь 35-39 насны эхээс, 4.1% нь 40-44 насны эхээс, 0.2% нь 45-аас дээш насны эхээс тус тус мэндэлжээ.

Хүснэгт 9. Төрөлт, эхийн насны бүлгээр

Насны бүлэг	2000	2008	2016	2017	2018
Бүгд	11 771	25 426	39 074	35 862	35 300
15-19	764	935	1 496	1 368	1 241
20-24	4 202	7 554	8 331	7 385	6 090
25-29	3 677	7 850	13 311	11 886	11 512
30-34	2 082	5 470	9 289	8 865	9 635
35-39	788	2 864	5 206	4 999	5 321
40-44	219	670	1 367	1 288	1 435
45-49	20	83	74	71	66

Зураг 7. Хүүхэд төрүүлсэн эхчүүд, боловсролын түвшнээр



2018 онд хүүхэд төрүүлсэн эхчүүдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 21355 (60.5%) нь дээд болон түүнээс дээш, 12449 (35.3%) нь бүрэн дунд, 433 (1.2%) нь суурь, 665 (1.9%) нь тусгай мэргэжлийн дунд болон техникийн мэргэжлийн, 94 (0.3%) нь бага боловсролтой, 386 (0.8%) нь ямар нэг боловсрол эзэмшээгүй эмэгтэйчүүд байна.

Түүнчлэн хүүхэд төрүүлсэн эхчүүдийн 3895 (11.0%) нь гэр бүлгүй, 31387 (89.0%) нь гэр бүлтэй хүмүүс байна.

Хүснэгт 10. Төрсөн хүүхдийн тоо, дүүргээр

Үзүүлэлт	2000	2008	2016	2017	2018
Нийслэлийн дүн	11 771	25 426	39 074	35 862	35 300
Багануур	457	683	644	618	670
Багахангай	86	90	92	114	98
Баянгол	1 922	3 810	6 178	6 228	5 561
Баянзүрх	2 260	5 672	9 265	8 606	8 611
Налайх	440	745	860	856	859
Сонгинохайрхан	2 538	5 756	8 905	7 682	7 659
Сүхбаатар	1 219	2 862	3 515	3 119	3 168
Хан-Уул	1 149	2 469	5 140	4 796	4 918
Чингэлтэй	1 700	3 339	4 475	3 843	3 756
Улсын дүн	48 721	63 768	79 920	75 321	78 444
Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	24.2	39 9	48.9	47.6	45.0

Хүснэгт 11. Нас барсан хүний тоо, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	2000		2008		2016		2017		2018	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Бүгд	5 037	2 158	6 336	2 533	7275	2891	7 605	2 964	7 561	2 977
<1	470	220	475	193	611	289	489	214	555	239
1-4	177	68	76	33	102	44	100	45	84	31
5-9	38	14	34	10	40	15	48	16	28	13
10-14	42	16	29	14	35	16	42	17	16	7
15-19	73	24	78	28	74	27	60	22	39	12
20-24	112	35	160	37	88	15	112	32	71	25
25-29	175	58	189	48	187	62	183	67	134	45
30-34	191	57	273	63	221	65	285	88	250	72
35-39	244	85	296	81	324	86	350	96	336	97
40-44	301	82	438	134	455	125	483	108	455	133
45-49	250	87	553	170	529	134	568	157	631	162
50-54	320	125	528	197	732	225	738	212	720	203
55-59	349	136	458	171	718	230	807	243	780	262
60-64	372	151	485	199	569	225	644	221	708	270
65-69	471	205	537	231	593	255	580	262	602	246
70+	1 452	795	1 727	924	1 997	1 078	2 116	1 164	2 152	1 160

Нийслэлийн хүн амын нас баралтын түвшин сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой байна. 2018 онд 7.6 мянган хүн нас барсан нь улсын хэмжээнд нас барсан нийт хүний 42.3 хувийг эзэлж байгаа юм. Нас барсан хүн амын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин өндөр хэвээр байгаа нь нас ахих тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч, эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхээс илүү байгаагийн гол шалтгаан болж байна. 2000 онд нас барсан хүний 57.2 хувь нь эрэгтэйчүүд байсан бол 2008 онд 60.0 хувь, 2016 онд 60.3 хувь, 2017 онд 61.0 хувь, 2018 онд 60.6 хувь болжээ.

Хүснэгт 12. Эх, нялхсын эндэгдлийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2000	2008	2016	2017	2018
Эхийн эндэгдэл	25	15	17	12	12
Үр хөндөлт	7 241	6 358	13 805	12 661	11 074
Нялхсын эндэгдэл	470	475	611	489	555
Нялхсын эндэгдэлийн коэффициент	39.9	18.7	15	12.7	13.6
Улсын дунд нийслэлийн эзлэх хувь			46.5	48.5	53.5

Нялхсын нас баралтын коэффициент буюу амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас нэг хүртэл насандаа эндсэн хүүхдийн тоо 2018 онд 13.6 болж 2000 оноос 26.3, 2008 оноос 5.1, 2016 оноос 1.4 промилээр тус тус буурч, өмнөх оноос 0.9 промилээр өссөн байна.

Зураг 8. Хүн амын дундаж наслалт



2000 онд нийслэлийн хүн амын дундаж наслалт улсын дунджаас 1.4 жилээр, 2008 онд 0.23 жил, 2016 онд 1.9 жил, 2017 онд 1.62 жил, 2018 онд 1.46 жилээр дээгүүр үзүүлэлттэй болсон байна.

Зураг 9. Гэрлэлт ба гэр бүл цуцлалт



2018 онд 10890 хос гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн нь өмнөх оноос 491 хүнээр (4.7%), мөн 2528 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 80 хүнээр (3.3%) тус тус өсөж, 669 хүүхэд үрчлэгдсэн нь өмнөх оноос 40 хүнээр (5.6%) буурчээ.

Зураг 10. Гэр бүл цуцлалт, хамт амьдарсан жилээр



2018 онд гэр бүл цуцлуулсан гурван хос тутмын нэг нь 10-14 жил хамт амьдарсан байгаа нь гэр бүл салалтыг амьдарсан хугацаагаар харуулсан үзүүлэлтийн хамгийн өндөр хувийг эзэлж байв.

Түүнчлэн 530 (21.0%) нь 20 ба түүнээс дээш жил, 427 (16.9%) нь 7-9 жил, 314 (12.4%) нь 15-19 жил, 296 (11.7%) нь 4-6 жил, 161 (6.4%) нь 1-3 жил, 13 (0.5%) нь нэг жил хүртэлх хугацаанд хамт амьдарсны эцэст гэр бүлээ цуцлуулсан байна.

Зураг 11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шалтгаанаар



2018 оны жилийн эцэст нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 35.6 мянган иргэн амьдарч байгаа нь өмнөх оноос 1343 хүнээр (3.9%) өссөн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэдийн 87.7 хувь нь 18 ба түүнээс дээш насны хүмүүс байхад 44.8 хувь нь төрөлхийн, үлдэх хувь нь өвчнөөр болон осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Хүснэгт 13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хүйс, дүүргээр

Дүүрэг	2000		2008		2016		2017		2018	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Нийслэлийн дүн	8 937	-	21 062	9 913	33 713	15 895	34 246	15 893	35 589	15 861
Багануур	459	-	728	300	987	427	1 004	411	1 039	435
Багахангай	37	-	115	44	164	63	157	65	163	70
Баянгол	902	-	3 055	1 474	4 693	2 326	4 819	2 284	5 873	2 585
Баянзүрх	1 313	-	3 991	1 953	7 794	3 793	7 638	3 699	8 026	3 643
Налайх	867	-	1 296	448	1 760	723	1 731	681	1 626	753
Сонгинохайрхан	2 319	-	4 001	1 871	7 284	3 308	7 254	3 263	7 857	3 482
Сүхбаатар	687	-	2 514	1 158	3 181	1 443	3 138	1 466	2 974	1 275
Хан-Уул	1 094	-	2 469	1 241	3 861	1 921	3 899	1 834	3 930	1 749
Чингэлтэй	1 259	-	2 893	1 424	3 989	1 891	4 606	2 190	4 101	1 869

2018 онд хагас өнчин хүүхдийн тоо 11676 болж өмнөх оноос 420 (3.7%) хүүхдээр өсөж, бүтэн өнчин хүүхдийн тоо 1399 болж өмнөх оноос 91 (6.1%) хүүхдээр буурсан. Хагас өнчин хүүхдүүдийн 5753 (49.3%) нь эмэгтэй, бүтэн өнчин хүүхдүүдийн 745 (53.3%) нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 14. Өнчин хүүхдийн тоо, дүүргээр

Дүүрэг	Бүтэн өнчин хүүхдийн тоо					Хагас өнчин хүүхдийн тоо				
	2000	2008	2016	2017	2018	2000	2008	2016	2017	2018
Нийслэлийн дүн	1 047	1 729	1 573	1 490	1 399	10 727	12 154	11 512	11 256	11 676
Багануур	48	40	39	37	38	305	313	287	275	414
Багахангай	10	11	10	7	8	108	76	48	60	75
Баянгол	150	186	149	139	122	1 105	1 394	887	831	1 035
Баянзүрх	168	452	402	413	366	2 686	3 162	2 889	2 622	2 800
Налайх	48	62	75	71	65	934	531	457	520	510
Сонгинохайрхан	243	409	416	349	345	1 887	2 782	2 655	2 572	2 593
Сүхбаатар	126	188	154	150	144	1 274	1 358	1 285	1 304	1 194
Хан-Уул	143	204	160	164	150	1 186	1 268	1 400	1 457	1 436
Чингэлтэй	111	177	168	160	161	1 242	1 270	1 604	1 615	1 619

Нийт өнчин хүүхдийн 1399 (10.7%) нь бүтэн өнчин, 11676 (89.3%) нь хагас өнчин, 1425 (10.8%) нь 0-4 насны, 3599 (27.5%) нь 5-9 насны, 4608 (35.2%) нь 10-14 насны, 3443 (26.3%) нь 15-17 насны хүүхдүүд байна.

Нийслэлийн өрхийн аж байдал:

2018 онд Монгол Улсын нийт өрхийн 387453 (43.3%) нь нийслэлд аж төрж байна. Нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 3.7 болов. Нийслэлийн өрхийн тоо 2000 оноос 220.3 (2.3 дахин) мянган өрхөөр, 2006 оноос 160.6 (70.8%) мянган өрхөөр, өмнөх 2017 оноос 1.3 (0.3%) мянган өрхөөр тус тус нэмэгджээ.

Хүснэгт 15. Нийслэлийн өрхийн тоо, дүүргээр, мянган өрх

Дүүрэг	2000	2006	2016	2017	2018
Нийслэлийн дүн	167.2	226.9	380.8	386.2	387.5
Багануур	4.7	6.6	8.6	8.5	8.6
Багахангай	0.8	0.8	1.2	1.2	1.3
Баянгол	30.0	35.4	58.2	58.8	59.5
Баянзүрх	33.6	50.8	93.7	95.0	95.7
Налайх	5.3	7.0	10.4	10.5	10.6
Сонгинохайрхан	33.1	48.0	84.9	86.2	84.2
Сүхбаатар	20.8	28.4	38.0	38.3	38.6
Хан-Уул	15.1	21.4	45.2	47.2	48.9
Чингэлтэй	23.8	28.4	40.6	40.5	40.0
Улсын дүн	554.0	632.5	869.8	885.6	894.5
Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	30.2	35.9	43.8	43.6	43.3

Нэг өрхийн дундаж ам бүлийн тоо 1990 оны эхэнд 5.1 байсан бол энэ үеэс буурсаар 2000 онд дундаж ам бүлийн тоо 4.6, 2006 онд 4.7, 2018 онд 3.7 болсон нь жил ирэх тусам нэг өрхөд ногдох хүний тоо буурч байгааг харуулж байна.

Зураг 12. Нийслэлийн өрхийн тоо, дундаж ам бүл

Нийт өрхийн 14053 (3.6%) нь 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх байна. Нийслэл хотод ганц бие өндөр настай 7756 хүн, мөн тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай 273 хүн амьдарч байна.

Хүснэгт 16. Өрхийн зарим үзүүлэлт

Төрөл	2004	2006	2016	2017	2018
18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх	9 931	7 873	12 503	10 300	14 053
Ганц бие өрхийн тоо, бүгд	4 109	2 824	6 119	6 908	7 756
Үүнээс: эрэгтэй (60 ба түүнээс дээш настай)	1 613	1 086	1 971	2 150	2 322
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	2 496	1 738	4 148	4 758	5 434
Тэтгэвэр, тэтгэмж тогтоогдоогүй өндөр настай хүн, бүгд	759	373	127	191	273
Үүнээс: эрэгтэй (60 ба түүнээс дээш настай)	306	176	58	78	89
эмэгтэй (55 ба түүнээс дээш настай)	453	197	69	113	184

Зураг 13. 16 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон хүн, хүйсээр



2018 онд 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй 12002 хүн байгаагийн 6861 (57.2%) нь 3 хүртэл хүүхэдтэй, 4744 (39.5%) нь 3-5 хүүхэдтэй, 397 (3.3%) нь 6 ба түүнээс дээш хүүхэдтэй байна.

Нийслэлд 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхчүүдийн тоо жил ирэх тусам буурч байна.

* 2013 оноос 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй хүний тоог гаргаж байна.

2018 онд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 19.0 мянга болж өмнөх оноос 1481 хүнээр (7.2%), өрх толгойлсон эцэг 1723 болж өмнөх оноос 91 хүнээр (5.0%) тус тус буурчээ.

Хүснэгт 17. Өрх толгойлсон, гэр бүлгүй хүний тоо, хүйс, дүүргээр

Дүүрэг	2005		2006		2016		2017		2018	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Нийслэлийн дүн	4 774	22 022	4 469	24 096	3 800	20 510	3 491	19 029	2 840	16 843
Багануур	116	969	106	1 048	131	593	109	617	146	740
Багахангай	90	69	32	114	19	151	11	54	11	66
Баянгол	321	2 453	425	2 782	307	1 880	213	1 469	183	1 419
Баянзүрх	834	3 986	683	4 912	697	4 407	661	4 607	633	4 197
Налайх	167	1 009	161	1 049	370	1 212	349	1 260	283	1 142
Сонгинохайрхан	1 440	3 988	1 081	3 993	666	3 526	703	3 062	558	2 945
Сүхбаатар	537	3 208	574	3 353	543	2 903	464	2 635	299	1 811
Хан-Уул	434	3 030	539	3 440	433	2 657	435	2 435	417	2 467
Чингэлтэй	835	3 310	868	3 405	634	3 181	546	2 890	310	2 056

2018 онд нийслэлд өрх толгойлсон буюу гэр бүлгүй эцэг, эхчүүд 19683 байгаа нь нийслэлийн нийт өрхийн 5.1 хувийг эзэлж байв. Эдгээр өрхүүдийн 14.4 хувийг эрэгтэйчүүд, 85.6 хувийг эмэгтэйчүүд толгойлж байна. Өрх толгойлсон эцэг, эхтэй өрхүүдийн 8526 (43.3%) нь 3 хүртэлх ам бүлтэй, 8540 (43.4%) нь 3-5 ам бүлтэй, 2617 (13.3%) нь 6 ба түүнээс дээш ам бүлтэй ажээ.

Өрхийн сууцны нөхцөл:

Нийслэлийн айл өрхүүдийн 50 гаруй хувь нь төвлөрсөн хангамжид холбогдсон орон сууцны хороололд амьдарч байсан бол 2003 оноос эхлэн гэр хороололд амьдардаг өрх, хүн амын тоо ихээр нэмэгдэж, 2004 онд 58.5 хувь, 2008 онд хамгийн их буюу 61.4 хувьд хүрч байв.

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилга нэмэгдэж байгаатай холбоотойгоор гэр хорооллын өрхийн эзлэх хувь бага зэрэг буурах хандлагатай байна. Тухайлбал, 2015 онд 58.1 хувь, 2016 онд 56.7 хувь, 2017 онд 55.7 хувь, 2018 онд 54.7 хувь болсон.

Зураг 14. Нийслэлийн өрх, байршлаар



Хүснэгт 18. Орон сууцны болон сууцны тусдаа байшин, гэрт амьдардаг өрх

Үзүүлэлт		2004	2008	2016	2017	2018
Нийт өрхийн тоо		205 498	251 758	380 828	386 218	387 453
Үүнээс:	Орон сууцны хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	85 290	97 114	164 807	171 062	175 445
	нийтийн орон сууцны	83 658	96 266	163 141	169 436	173 526
	тусдаа тохилог орон сууц	1 235	567	1 630	1 617	1 909
	орон гэргүй	397	281	36	9	10
	Гэр хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	120 208	154 644	216 021	215 156	212 008
	тохилог орон сууцанд	1 263	1 963	2 022	2 045	1 989
	байшинд амьдардаг	61 381	85 016	109 327	110 055	109 570
	монгол гэрт амьдардаг	56 202	66 538	104 462	102 884	100 312
	орон гэргүй	1 362	1 127	210	172	137
Орон сууцны хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь		41.5	38.6	43.3	44.3	45.3
Гэр хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь		58.5	61.4	56.7	55.7	54.7

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдэж 2010 оноос орон сууцны хорооллын өрхийн тоо 60 гаруй мянган өрхөөр нэмэгдсэн. 2018 онд нийслэлийн нийт өрхийн 54.7 хувь нь гэр хороололд, 45.3 хувь нь орон сууцны хороололд оршин сууж байгаа нь өмнөх оноос орон сууцанд орсон өрх 1.0 хувиар нэмэгдэв.

Орон сууцны хорооллын өрх жилд дунджаар 5000 орчим өрхөөр нэмэгдэж, 2018 онд 175.4 мянга болсон бол гэр хорооллын өрх жилд дунджаар 8000 орчим өрхөөр нэмэгдэж байгаа ч сүүлийн 3 жил дараалан буурч 2018 онд 212.0 мянга болоод байна.

Хүснэгт 19. Нийслэлийн өрх, байршил, сууцны төрлөөр, 2018 он

Дүүрэг	Нийт өрх	Үүнээс:						
		Орон сууцны хороололд			Гэр хороололд			
		Нийтийн орон сууц	Тусдаа тохилог орон сууц	Орон гэргүй	Тусдаа тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Монгол гэр	Орон гэргүй
Нийслэлийн дүн	387 453	173 526	1 909	10	1 989	109 570	100 312	137
Багануур	8 569	3 487	64	1	35	1 810	3 166	6
Багахангай	1 272	726	-	1	6	118	421	-
Баянгол	59 536	47 067	581	-	243	6 316	5 325	4
Баянзүрх	95 714	43 500	298	2	334	24 616	26 958	6
Налайх	10 606	2 516	38	-	29	3 518	4 502	3
Сонгинохайрхан	84 236	22 302	132	-	227	31 560	29 994	21
Сүхбаатар	38 563	18 826	33	-	311	10 422	8 960	11
Хан-Уул	48 940	26 835	761	5	341	11 277	9 705	16
Чингэлтэй	40 017	8 267	2	1	463	19 933	11 281	70

Зураг 15. Нийслэлийн өрх, сууцны төрлөөр



Гэр хорооолод суурьшсан өрхийн тоо 2005-2010 он хүртэл 19796 өрхөөр, 2010-2015 он хүртэл 29465 өрхөөр нэмэгдэж байсан бол 2016 онд 1380 өрх, 2017 онд 865, 2018 онд 3148 өрхөөр тус тус буурч 212.0 мянга болсон. Гэр хорооолод суурьшсан эдгээр өрхийн 100.3 мянга (47.3%) нь монгол гэрт, 111.6 мянга (52.6%) нь байшин сууцанд амьдарч байв.

Зураг 16. Орон гэргүй өрх, оршин суугаа байршлаар



2018 онд нийт 181 өрхийн 427 хүн орон гэргүйн улмаас урц овоохой, шатны хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч байжээ.

Орон гэргүй дээрх 147 өрхийн 303 хүн гэр хорооолод амьдарч байю. Харин 2018 онд орон гэргүй, орон сууцны зориулалтын бус нөхцөлд амьдардаг байсан 25 өрхийн 124 хүн гэр, байшин сууцтай болсон байна.